

□ндэсний статистикийн газрын даргын  
1999 оны 72 дугаар тушаалаар батлав.

## **АЖИЛГҮЙЧҮҮДИЙН МЭДЭЭЛЛИЙН ЦЭЦЭЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ**

Улсын хэмжээгээр мөрдөгдөж байгаа ажилгүйчүүдийн сарын мэдээ /маягт АХ-3/-ний маягтын гол үзүүлэлт болох ажилгүйчүүдийг тооцох аргачлалыг одоогийн тавигдаж буй шаардлагыг хангах, мэдээлэл гаргаж буй албадыг нэгдсэн нэг ойлголттой болгох зорилгоор олон улсын аргачлалтай уялдуулан, өөрийн орны нөхцөлд зохицуулан шинэчлэн боловсрууллаа.

Хөдөлмөрийн статистикийн Олон Улсын Арван Гуравдугаар Бага хурлаас “1982 оны 10-р сард” баталсан эдийн засгийн идэвхитэй хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл болон бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн тухай тогтоолыг үндэслэн «ажилгүйчүүд» гэсэн ойлголтыг манай орны нөхцөлд дараахь байдлаар тодорхойлно.

Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй эрж, хайж байгаа хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлсэн хүмүүсийг ажилгүйчүүд гэнэ.

**Хөдөлмөрлөх насны хүмүүст** - Тус улсын хуулиар зөвшөөрөгдсөн 16-54 насны эмэгтэйчүүд, 16-59 насны эрэгтэйчүүд;

**Хөдөлмөр эрхлэх чадвартай хүмүүст** - Хөдөлмөрийн бүрэн чадвартай мөн чадвараа тодорхой хувиар алдсан боловч хөдөлмөр эрхлэх боломжтой хүмүүс

**Цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй хүмүүст** - Цалин хөлстэй ажил хийдэггүй, хувиараа хөдөлмөр эрхэлж орлого олдоггүй хүмүүс

**Ажиллахад бэлэн хүмүүст** -Бүртгүүлсэн хугацаандаа хөдөлмөр зохицуулалтын албанаас тухайн иргэний мэргэжил, боловсрол, ажлын ур чадвар болон урьд нь ажиллаж байсан ажлын нөхцлийг бууруулахгүйгээр санал болгосон цалин хөлстэй ажил хийх буюу хувиараа хөдөлмөр эрхлэхэд бэлэн байгаа мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих идэвхитэй бодлогод “мэргэжлийн сургалт, нийтийг хамарсан ажил” хамрагдаад 3 сар болоогүй байгаа хүмүүсийг ажиллахад бэлэн

хүмүүс гэж үзнэ.

**Ажил идэвхитэй эрж, хайж байгаа хүмүүст** -Хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлсэн өдрөөсөө хойш 3 сарын дотор нэгээс доошгүй удаа Хөдөлмөр зохицуулалтын албанд ажил идэвхитэй хайж байгаагаа ирж мэдэгдэж байгаа хүмүүсийг ажил идэвхитэй эрж, хайж байгаа хүмүүс гэнэ. Хэрэв 3 сарын дотор ирж мэдэгдэж, асууж лавлахгүй бол ажилгүйчүүдийн бүртгэлээс хасагдах болно.

ooOoo